



БАЯНГОЛ ДҮҮРГИЙН
СТАТИСТИКИЙН
ХЭЛТЭС

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САЛБАР-2025



Улаанбаатар хот
2026 он



**БАЯНГОЛ ДҮҮРГИЙН
СТАТИСТИКИЙН
ХЭЛТЭС**

НИЙГМИЙН ДААТГАЛ-2025

**Улаанбаатар хот
2026 он**

ТАНИЛЦУУЛГЫГ БОЛОВСРУУЛСАН:

Т.Энхмэнд

Барилга, хэрэглээний үнэ хариуцсан
мэргэжилтэн

ТАНИЛЦУУЛГЫГ ХЯНАСАН:

Г.Чинжаргал

Хэлтсийн дарга

Б.Шинэцэцэг

Ахлах мэргэжилтэн

Улаанбаатар хот, Баянгол дүүрэг
27-р хороо, Замчдын гудамж-3
Засаг даргын Тамгын газрын байр
112, 114 тоот
Утас: 11-301637, 70122688
Цахим хаяг: bayangol@nso.mn
Цахим хуудас: <http://www.1212.mn>
<http://www.ubstat.mn>
<http://www.bgd.mn>



ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

ХҮСНЭГТ 1. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, жил бүрийн эцэст	10
ХҮСНЭГТ 2. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГА, жил бүрийн эцэст	11
ХҮСНЭГТ 3. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ АВАГЧИД, жил бүрийн эцэст ...	12

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

ЗУРАГ 1.НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, өсөлт, бууралтын хувь, сая төгрөгөөр, жилийн бүрийн эцэст	8
ЗУРАГ 2.НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, дүнд эзлэх хувиар, 2025 оны жилийн эцсийн байдлаар.....	9
ЗУРАГ 3.НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, дүнд эзлэх хувиар, жилийн бүрийн эцэст.....	9
ЗУРАГ 4.ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГА, тэрбум төгрөгөөр, жил бүрийн эцэст.....	10
ЗУРАГ 5.ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГА, дүнд эзлэх хувиар, 2025 оны жилийн эцсийн байдлаар.....	11
ЗУРАГ 6.ТЭТГЭВЭР АВАГЧДЫН ТОО, дүнд эзлэх хувиар, жил бүрийн эцэст.....	12
ЗУРАГ 7.ТЭТГЭВЭР АВАГЧДЫН ТОО, жил бүрийн эцэст.....	13

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

МУ	Монгол Улс
ҮСХ	Үндэсний Статистикийн хороо
ҮОМШӨ	Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин
ХЧТАТ	Хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж



НИЙГМИЙН ДААТГАЛ

Нийгмийн даатгалын сангийн орлого өмнөх оны мөн үеэс 9.8 хувиар буурсан бол зарлага 14.7 хувиар өсжээ.


Нийгмийн хамгаалал гэдэг нь хүн амыг нийгэм, эдийн засгийн эмзэг байдлаас урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгахад чиглэсэн төрийн болон хувийн хэвшлийн бодлого, хөтөлбөрүүдийн цогц ойлголт юм. Нийгмийн хамгааллын зохих түвшинд хамрагдах нь хүний үндсэн эрхээс гадна хүний сайн сайхан байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээ юм. Үүнийг олон улсын хэд хэдэн тунхаглал ба олон нийгмийн хамгааллын тухай олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээнүүдэд тодорхой хүлээн зөвшөөрсөн байдаг.

Нийгмийн даатгал нь хүмүүсийн амьдрах чадавхын эрсдэлийг оновчтой зөв тодорхойлж, түүнээс урьдчилан сэргийлж хамгаалах, нэгэнт эрсдэлд өртсөн тохиолдолд үр дагаврыг нь багасгаж арилгахад чиглэгддэг.

Монголын Улсын нийгмийн даатгалын тогтолцоо нь даатгуулагч ажилтан, ажил олгогчийн төлсөн шимтгэл дээр суурилах бөгөөд хэд хэдэн төрлийн тэтгэвэр, тэтгэмжийг олгож байна. Үүнд тэтгэвэрийн, тэтгэмжийн, ҮОМШӨ-ний, ажилгүйдлийн, эрүүл мэндийн даатгал гэсэн 5 төрлийн даатгал байна.

ЗУРАГ 1.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, өсөлт, бууралтын хувь, сая төгрөгөөр, жил бүрийн эцэст




Нийгмийн даатгалын сангийн орлого сүүлийн жилүүдэд нэмэгдэх хандлагатай байсан хэдий ч 2025 онд 557116.5 сая болж, өмнөх оны мөн үеэс 60569.8 (9.8%) сая төгрөгөөр буурсан харагдаж байгаа бөгөөд энэ нь эрүүл мэндийн

даатгалын сангаас орлого, зарлага төвлөрөөгүй, мөн ажил эрхлэлтийн түвшин буурах, цалин хөлс багасах, шимтгэл төлөлт тасалдах зэрэг хүчин зүйлсийн нөлөөгөөр тус санд төвлөрөх шимтгэлийн хэмжээ багассантай холбоотой байна.

ЗУРАГ 2.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, дүнд эзлэх хувиар, 2025 оны жилийн эцсийн байдлаар




Даатгалын санд хуримтлуулсан нийт шимтгэлийн орлогын 82.9 хувь нь тэтгэврийн даатгалын санд, 5.1 хувь нь үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний (ҮОМШӨ) даатгалын санд, 8.8 хувь нь тэтгэмжийн даатгалын санд, 3.2 хувь нь ажилгүйдлийн даатгалын санд тус тус төвлөрчээ.

2019 оноос Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 19.3 дахь заалтын дагуу Нийгмийн Даатгалын Ерөнхий газар нь Эрүүл мэндийн даатгалын сангийн шимтгэлийн орлогыг төвлөрүүлдэг болсон. Мөн Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага нь 2019 оноос эхлэн Эрүүл мэндийн даатгалын сангийн мэдээлэлд тусгагддаг болсон. Нийгмийн даатгалын

сангийн орлого өмнөх оноос 60.6 (9.8%) сая төгрөгөөр буурахад тэтгэмжийн даатгалын сангийн орлого 15.3 (23.7%) сая төгрөгөөр, үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний (ҮОМШӨ) даатгалын сангийн орлого 9.6 (25.4%) сая төгрөгөөр, ажилгүйдлийн даатгалын сангийн орлого 8.3 (32.4%) сая төгрөгөөр, буурсан нь голлон нөлөөлсөн байна.

ЗУРАГ 3.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, дүнд эзлэх хувиар, жил бүрийн эцэст



Нийгмийн даатгалын сангаас 2025 оны жилийн эцсийн байдлаар даатгуулагч иргэдэд 469.7 тэрбум төгрөгийг тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, тусламж, үйлчилгээний зардалд зарцуулж, өнгөрсөн оны мөн үеэс 60.0 (14.7%) сая төгрөгөөр өссөн байна.


ХҮСНЭГТ 1. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, жил бүрийн эцэст

Үзүүлэлт	2022	2023	2024	2025	2025 2024
	сая төгрөг				хувь
Нийт орлого	466 426.2	549 718.7	617 686.3	557 116.5	-9.8
Тэтгэврийн даатгалын сан	346 543.7	395 726.8	411 930.4	462 101.8	12.2
Тэтгэмжийн даатгалын сан	27 828.8	34 944.4	64 584.4	49 274.6	-23.7
Эрүүл мэндийн даатгалын сан	59 413.0	74 868.7	77 475.8	-	-
ҮОМШӨ-ний даатгалын сан	23 431.5	28 906.1	37 910.6	28 299.9	-25.4
Ажилгүйдлийн даатгалын сан	9 209.3	15 272.6	25 785.1	17 440.2	-32.4
Нийт зарлага	256 341.4	318 657.2	409 654.9	469 720.5	14.7
Тэтгэврийн даатгалын сан	224 737.1	277 919.3	366 236.9	421 787.1	15.2
Тэтгэмжийн даатгалын сан	20 105.3	24 303.9	23 257.4	26 078.3	12.1
ҮОМШӨ ² -ний даатгалын сан	1 631.5	1 910.0	2 443.2	2 713.5	11.1
Ажилгүйдлийн даатгалын сан	9 867.6	14 523.9	17 717.4	19 141.6	8.0

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 63 дугаар тогтоолоор Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа болон цэргийн алба хаасны тэтгэвэр авагчийн авч байгаа тэтгэврийн хэмжээг 15 хувиар тус тус нэмэгдүүлэн Нийгмийн даатгалын сангаас олгох бүрэн тэтгэврийн болон цэргийн алба

хаасны тэтгэврийн доод хэмжээг 500000 (таван зуун мянга) төгрөгөөр, нийгмийн даатгалын сангаас олгох хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэврийн доод хэмжээг 400000 (дөрвөн зуун мянган) төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоосон нь нийгмийн даатгалын сангийн зарлагын өсөлтөд нөлөө үзүүлж байна.

ЗУРАГ 4. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГА, тэрбум төгрөгөөр, жил бүрийн эцэст



Нийгмийн даатгалын сангуудын зарлагыг өнгөрсөн онтой харьцуулахад тэтгэврийн даатгалын сан 55.6 (15.2%) сая төгрөгөөр, тэтгэмжийн даатгалын сан 2.8 (12.1%) сая

төгрөгөөр, ажилгүйдлийн даатгалын сан 1.4 (0.8%) сая төгрөгөөр, ҮОМШӨ-ний даатгалын сан 3.0 (11.1%) сая төгрөгөөр тус тус өссөн байна.


ХҮСНЭГТ 2. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГА, жил бүрийн эцэст

Үзүүлэлт	2021	2022	2023	2024	2025	2025 2024
	сая төгрөг					хувь
Нийт зарлага	203 470.1	256 737.1	318 657.0	409 654.9	469 720.5	14.7
Тэтгэврийн даатгалын сан	174 827.8	224 737.1	277 919.2	366 236.9	421 787.1	15.2
Өндөр насны	141 252.2	179 483.5	223 651.3	298 234.8	345 035.5	15.7
Тахир дутуугийн	15 243.5	20 947.3	22 896.4	27 632.4	30 431.1	10.1
Тэжээгчээ алдсаны	4 089.9	5 853.3	6 692.4	8 398.7	9 635.4	14.7
Цэргийн тэтгэвэр	14 242.2	18 452.9	24 679.1	31 970.9	36 660.2	14.7
Бусад	-	-	-	-	24.9	-
Тэтгэмжийн даатгалын сан	19 815.9	20 105.3	24 303.9	23 257.4	26 078.3	12.1
Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж	4 634.7	4 300.5	4 750.1	5 273.6	6 144.5	16.5
Жирэмсэн, амаржсаны тэтгэмж	15 071.2	15 723.8	18 325.8	15 921.5	17 877.6	12.3
Оршуулгын тэтгэмж	110	81.0	1 228.0	1 784.0	1 828.0	2.5
Бусад	-	-	-	278.3	228.2	-18.0
ҮОМШӨ-ний даатгалын сан	1 390.9	1 631.5	1 910.0	2 443.2	2 713.5	11.1
Тахир дутуугийн тэтгэмж	1 130.2	1 295.5	1 494.2	1 832.1	1 861.2	1.6
Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	185	210.8	237.5	313.8	353.7	12.7
Тэтгэмж, төлбөр	73.2	120.5	172.3	290.2	396.2	36.5
ҮОМШӨ*-ний сувилал	2.5	4.7	6.0	7.1	102.4	1.3**
Ажилгүйдлийн даатгалын сан	7 435.5	9 867.6	14 523.9	17 717.4	19 141.6	8.0
Ажилгүйдлийн тэтгэмж	7 435.5	9 867.6	14 523.9	17 717.4	19 140.3	8.0
Бусад	-	-	-	-	1.3	-

**:-дахин их

ЗУРАГ 5.

ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГА, дүнд эзлэх хувиар, 2025 оны жилийн эцсийн байдлаар



Нийт зардлын 89.8 хувийг тэтгэврийн, 0.6 хувийг ҮОМШӨ-ний, 5.6 хувийг тэтгэмжийн, 4.0 хувийг ажилгүйдлийн даатгалын сангаас олгосон зардал эзэлж байна. 2025 оны жилийн эцсийн байдлаар нийгмийн даатгалын сангаас 58311 иргэнд 469720.5 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгогдсоны 35702 иргэнд 421787.1 сая төгрөгийг тэтгэврийн даатгалын сангаас, 17912 иргэнд 26078.3 сая төгрөгийг тэтгэмжийн даатгалын сангаас, 4325 иргэнд 19141.6 сая төгрөгийг ажилгүйдлийн даатгалын сангаас, 372 иргэнд 2713.5 сая төгрөгийг үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас тус тус зарцуулсан байна.

ХҮСНЭГТ 3.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ АВАГЧДЫН ТОО, жил бүрийн эцэст

Үзүүлэлт	2021	2022	2023	2024	2025	2025 2024
	сая төгрөг					хувь
Нийт зарлага	69 107	64 666	63 949	57 286	58 311	1.8
Тэтгэврийн даатгалын сан	30 215	31 844	33 120	34 801	35 702	2.6
Өндөр насны	23 414	24 770	26 032	27 728	28 711	3.5
Тахир дутуугийн	4 039	4 146	4 089	3 980	3 811	-4.2
Тэжээгчээ алдсаны	1 054	1 136	1 162	1 187	1 229	3.5
Цэргийн тэтгэвэр	1 708	1 792	1 837	1 906	1 951	2.4
Тэтгэмжийн даатгалын сан	35 586	29 166	26 883	17 978	17 912	-0.4
Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж	27 529	22 444	19 321	12 281	12 923	5.2
Жирэмсэн, амаржсаны тэтгэмж	7 947	6 641	6 948	4 805	4 075	-15.2
Оршуулгын тэтгэмж	110	81	614	892	914	2.5
ҮОМШӨ-ний даатгалын сан	297	329	350	313	372	18.8
Тахир дутуугийн тэтгэмж	178	169	166	129	140	8.5
Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	23	22	22	24	25	4.2
Тэтгэмж, төлбөр	91	116	145	131	207	58.0
ҮОМШӨ*-ний сувилал	5	22	17	29	-	-
Ажилгүйдлийн даатгалын сан	3 009	3 327	3 596	4 194	4 325	3.1
Ажилгүйдлийн тэтгэмж	3 009	3 327	3 596	4 194	4 325	3.1


Тэтгэвэр авагчийн 80.4 хувийг өндөр настны тэтгэвэр эзэлж байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 983 (3.5%) хүнээр нэмэгдсэн байна.

2025 онд тэтгэврийн даатгалын сангаас 35702 иргэнд 421.8 тэрбум төгрөгийн тэтгэвэр олгогдсоноос 28711 (өндөр насны тэтгэвэр авагч) иргэнд 345.0 (81.8%) тэрбум төгрөгийг,

3811 (хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр авагч) иргэнд 30.4 (7.2%) төгрөгийг, 1951 (цэргийн тэтгэвэр авагч) иргэнд 36.7 (8.7%) тэрбум төгрөгийг, 1229 (тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч) иргэнд 9.6 (2.3%) тэрбум төгрөгийг тус тус олгосон байна.

ЗУРАГ 6.


ТЭТГЭВЭР АВАГЧДЫН ТОО, дүнд эзлэх хувиар, жил бүрийн эцэст



Тэтгэмжийн даатгалын сангаас 17912 хүнд 26078.3 сая төгрөгийн зарлага гарснаас хөдөлмөрийн чадвараа түр алдсан 12923 хүнд 6144.5 (23.6%) сая төгрөгийг, жирэмсэн болон

амаржсан 4075 эхэд 17877.6 (68.6%) сая төгрөгийг, 914 иргэний ар гэрт 1828.0 (7.0%) сая төгрөгийн оршуулгын тэтгэмжийг тус тус зарцуулаад байна.

ЗУРАГ 7. ТЭТГЭВЭР АВАГЧДЫН ТОО, жил бүрийн эцэст



Ажилгүйдлийн даатгалын сангаас 4325 хүнд 19141.6 сая төгрөгийг олгосон нь өнгөрсөн оноос 131 (3.1%) хүнээр, 1424.2 (8.0%) сая төгрөгөөр өссөн байна.

ДӨРӨВ. АРГА, АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР

Ойлголт, тодорхойлолт:

Нийгмийн даатгал: Иргэн, төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын санг бүрдүүлэн, даатгуулагч иргэн өндөр наслах, хөгжлийн бэрхшээлтэй буюу хөдөлмөрийн чадваргүй болох, өвчлөх, ажилгүй болох үед өөрт нь, тэрчлэн нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох зориулалттай нийгэм, эдийн засгийн арга хэмжээ юм.

Нийгмийн даатгалын сан: Ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах, нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн мөнгөн хөрөнгийг хэлнэ.

Даатгуулагч: Хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг хэлнэ.

Тэтгэвэр: Даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөдөлмөрийн чадвараа алдсан бол хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл,

эсхүл өндөр насны тэтгэвэр авах насанд хүртэл, нас барахад нь түүний асрамжид байсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүнд нийгмийн даатгалын сангаас сар бүр олгох мөнгөн олговор юм.


Тэтгэмж: Хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдах, жирэмсний, амаржсаны чөлөө эдлэх, ажилгүй болох тохиолдолд даатгуулагч өөрт нь, даатгуулагч нас барах тохиолдолд гэр бүлд нь хууль заасан болзол, нөхцөлийн дагуу нийгмийн даатгалын сангаас тодорхой хугацаанд буюу нэг удаа олгох мөнгөн олговор байна.

Нийгмийн халамж: Эрүүл мэндийн доройтолтой, гэр бүлийн халамж, асрамж дутагдалтай, бие даан, эсхүл бусдын тусламжгүйгээр хэвийн амьдрах боломжгүй, өвөрмөц хэрэгцээ бүхий иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, тусалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд наад захын хэрэгцээг нь хангах зорилгоор улсаас тэтгэвэр, тэтгэмж олгох, тусгайлсан үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг нийгмийн халамж гэнэ.

Эх үүсвэр:

Дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн сарын мэдээ

СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙГ ХЭРХЭН АВАХ ВЭ?



Цахимаар:

www.1212.mn
www.ubstat.mn



www.nso.mn

Та статистик мэдээллийг байнга
авч байхыг хүсвэл **ЭНД ДАРЖ**
бүртгүүлнэ үү

Энэ хэсэгт өөрийн e-mail
хаягаа бүртгүүлснээр
статистикийн мэдээллийг
цаг алдалгүй тогтмол авч
байх болно.

SOCIAL NETWORK



Баянгол дүүргийн
Статистикийн хэлтэс



[www.twitter.com/
statistic_mn](https://www.twitter.com/statistic_mn)



Ухаалаг гар утас, таблет
ашиглан статистик мэдээлэл
авах **ezStat** аппликейшн



Статистикийн хэвлэмэл
бүтээгдэхүүнийг унших
МОНСТАТ аппликейшн



Download on the
App Store



Google play



Утсаар:



11-301637
70122688
70122668

